



**“ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 11 сарын 28 өдөр

Дугаар

А/24

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэг, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын дүрмийн 2.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Байгууллагын үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор “Хот тохижилтын газрын Хөдөлмөрийн дотоод журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг байгууллагын нийт ажилтан, албан хаагчдад үүрэг болгосугай.

3.Журмын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Захиргаа хүний нөөцийн хэлтэс (Б.Баасанбат)-т, журамд тусгагдсан хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэх зардлыг жил бүрийн төсөвт тусган батлуулахыг Хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч (Б.Даваасүрэн)-д тус тус даалгасугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/20 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Г.УУГАНБАЯР

